



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 0/259

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 126 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,461,395 /нэг сая дөрвөн зуун жаран нэгэн мянга гурван зуун ерэн таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн 126 дугаар цэцэрлэг /Д.Мандахайцэцэн/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 6 нэр төрлийн 1,461,395 /нэг сая дөрвөн зуун жаран нэгэн мянга гурван зуун ерэн таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 126 дугаар цэцэрлэг /Д.Мандахайцэцэн/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115030000645

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2019 оны 06 дугаар сарын 08 өдрийн
 0143 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 126 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Бүгд үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Эвдрэл гэмтэл | ЭБХХХК-ын хурлын шийдвэр |
|---|------------------|---------------|-------------|------------|-------------|------------------|--------------------|----------------|---------------|--------------------------|
| Машин, тоног төхөөрөмж | | | | | | | | | | |
| 1 | Хөлдөөгч | 10 | ш | 1 | 262,515 | 262,515 | 262,515 | - | Эвдэрсэн | Татах |
| 2 | Ногооны комбайн | 5 | ш | 1 | 168,090 | 168,090 | 168,090 | - | Эвдэрсэн | Татах |
| 3 | Зургийн аппарат | 5 | ш | 1 | 210,810 | 210,810 | 210,810 | - | Эвдэрсэн | Татах |
| 4 | Угаалгын машин | 10 | ш | 1 | 219,990 | 219,990 | 219,990 | - | Эвдэрсэн | Татах |
| 5 | Өнгөт принтер | 5 | ш | 1 | 270,000 | 270,000 | 270,000 | - | Эвдэрсэн | Татах |
| 6 | Өнгөт принтер | 4 | ш | 1 | 329,990 | 329,990 | 329,990 | - | Эвдэрсэн | Татах |
| Машин тоног төхөөрөмжийн дүн | | | | | 1,461,395 | 1,461,395 | 1,461,395 | | | |
| Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | | | | | | 1,461,395 | | | | |
| Актлах хөрөнгийн дүн | | | | | | | | | | |